



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/090/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас:261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn

Аудитор:Н. Нямсүрэн
Утас:260512 Цахим хаяг:nyamsuren@audit.gov.mn

Голден пэйж Аудит ХХК-ийн захирал: С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.21 № 07/1143
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 639 дүгээр тогтоолоор үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын дулааны тарифыг 16672 төгрөг, орон сууцны халаалтын тарифыг 12170 төгрөгөөр тооцон 2025 оны 5 сарын 1-ний өдрөөс мөрдөх болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад худалдан авах дулааны эрчим хүчний тарифыг 2,449.2 төгрөгөөс 5,5579.3 төгрөгөөр, Улаанбаатар төмөр замын тарифыг 8,670.8 төгрөгөөр, орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын тарифыг 2,550.0 төгрөгөөс 3,750.0 төгрөгөөр тус тус баталсан, нэг

тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээ цуцалсан, эцсийн хэрэглэгчийн тарифт өөрчлөлт ороогүй байна.

Бусад асуудал

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт (АОУС), Төрийн аудитын тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан гарын авлага, холбогдох заавар журмын дагуу явуулна. Иймд Аудитор нь санхүүгийн тайланг материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн хангалттай нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж, гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн гүйцэтгэнэ. Аудитын үед санхүүгийн тайлан болон нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалт хийсний үндсэн дээр олж авдаг.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12 сарын 31
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,047,713,701.62	7,699,690,424.82
1.1.2	Дансны авлага	26,908,388,365.13	25,144,601,335.59
1.1.4	Бусад авлага	1,807,447,652.11	2,833,864,269.40
1.1.6	Бараа материал	569,771,784.94	680,977,822.30
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	37,850,880.33	117,469,412.29
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	33,371,172,384.13	36,476,603,264.40
1.2.1	Үндсэн хөрөнгө	317,734,442,031.63	337,631,626,575.86
1.2.2	Биет бус хөрөнгө	2,221,950,523.78	2,382,117,064.85
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	8,436,729,976.56	15,180,915,748.12
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	2,226,027,654.72	2,276,967,946.38
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	330,619,150,186.69	357,471,627,335.21
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	363,990,322,570.82	393,948,230,599.61
2.1.1.1	Дансны өглөг	5,351,715,445.63	
2.1.1.3	Татварын өр	1,537,284,102.22	1,238,859,304.62
2.1.1.5	Богино хугацаат зээл	546,439,107.21	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,339,060,299.52	2,465,063,267.65
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,173,715,417.65	559,743,275.66
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,948,214,372.23	4,263,665,847.93
2.1.2.1	Урт хугацаат зээл	101,054,003,813.97	131,556,237,619.74
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,690,563,157.00	2,705,656,704.17
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	103,744,566,970.97	134,261,894,323.91
2.2	Өр төлбөрийн нийт дүн	113,692,781,343.20	138,525,560,171.84
2.3.1	Төрийн өмч	224,711,247,384.81	224,711,247,384.81
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	17,380,143,548.78	17,234,638,136.78
2.3.9	Эздийн өмчийн бусад хэсэг	2,144,263,700.00	3,334,955,559.47
2.3.10	Хуримтлагдсан ашиг	6,061,886,594.03	10,141,829,346.71
2.3.11	Эздийн өмчийн дүн	250,297,541,227.62	255,422,670,427.77
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	363,990,322,570.82	393,948,230,599.61

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	147,616,313,956.80	147,648,874,030.72
2	Борлуулалтын өртөг	115,227,018,631.72	97,668,742,039.69
3	Нийт ашиг (алдагдал)	32,389,295,325.08	49,980,131,991.03
5	Хүүгийн орлого	44,664,947.15	109,170,217.85
8	Бусад орлого	1,005,799,722.02	3,767,571,960.33
9	Борлуулалт, маркетингийн зардал	54,962,765.03	241,948,295.89
10	Ерөнхий ба удирдлагын зардал	34,698,596,732.65	42,622,827,476.00
12	Бусад зардал	2,031,210,310.93	5,233,393,282.16
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(33,214.38)	8,873.04
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(489,814,190.84)	(1,492,729,377.32)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(3,834,857,219.58)	4,265,984,610.88
19	Орлогын татварын зардал	0.00	331,547,270.20
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(3,834,857,219.58)	3,934,437,340.68
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(3,834,857,219.58)	3,934,437,340.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	166,625,225,119.34	170,663,961,625.99
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	166,556,997,768.90	166,981,143,626.38
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		2,906,191,600.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	68,227,350.44	776,626,399.61
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	149,064,545,127.65	148,161,612,455.95
1.2.1	Ажиллагчдад төлсөн	11,524,683,033.00	15,311,727,572.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,817,801,285.87	4,890,761,210.72
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,344,778,827.76	1,125,854,667.72
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,126,316,902.80	1,931,438,835.84
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,620,020,339.50	6,590,066,215.51
1.2.9	Бусад мөнгөн зарлага	126,630,944,738.72	118,311,763,954.16
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,560,679,991.69	22,502,349,170.04
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,808,469,816.46	(18,850,381,319.88)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,942,188,777.00	8,163,011,979.15
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,866,281,039.46	10,687,369,340.73
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,808,469,816.46	(18,850,381,319.88)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	116,448.30	43,039.11
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	116,448.30	43,039.11
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	149,662.68	34,166.07
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	149,662.68	34,166.07
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	33,214.38	8,873.04
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,752,176,960.85	3,651,976,723.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	295,536,740.77	4,047,713,701.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,047,713,701.62	7,699,690,424.82

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	218,335,138,255.81	17,481,124,664.28	8,520,372,829.00	10,409,057,761.11	254,745,693,510.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				100,981,115.50	100,981,115.50
Залруулсан үлдэгдэл	218,335,138,255.81	17,481,124,664.28	8,520,372,829.00	10,409,057,761.11	254,745,693,510.20
Өмчид гаргасан өөрчлөлт	6,376,109,129.00		(6,376,109,129.00)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,044,316,879.21	2,044,316,879.21
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(100,981,115.50)		100,981,115.50	
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	224,711,247,384.81	17,380,143,548.78	2,144,263,700.00	6,061,886,594.03	250,297,541,227.62
Нягтлан бодох бүртгэлийн			1,192,589,079.47		1,192,589,079.47

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Өмчид гаргасан өөрчлөлт			(1,897,220.00)		(1,897,220.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				3,934,857,219.58	3,934,857,219.58
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(145,505,412.00)		145,505,412.00	
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	224,711,247,384.81	17,234,638,136.78	3,334,955,559.47	10,141,829,346.71	255,422,670,427.77

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он гүйц	2024 оны		Өөрчлөлт (2024 гүйц / 2024 төл)		
				Төлөв	Гүйц	зөрүү	хувь	
1	Худалдан авах ДЭХ	мян.Жоуль	32,189.3	34,196.5	32,891.9	(1,304.6)	-3.8	
2	Нийт орлого:	сая.төг	148,666.9	153,312.7	151,525.7	(1,787.0)	-1.2	
	Борлуулалтын орлого	сая.төг	147,616.3	150,019.0	147,648.9	(2,370.1)	-1.6	
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	1,050.6	3,293.7	3,876.8	583.1	17.7	
	Борлуулалтын орлого цуглуулалт	сая.төг	150,034.9	146,820.7	149,184.6	2,363.9	1.6	
3	1- Жоуль- ын	Орлого	төг/Жоуль	4,585.9	4,387.0	4,488.9	101.9	2.3
		Өөрийн өртөг	төг/Жоуль	4,721.0	4,400.2	4,429.5	29.3	0.7
4	Нийт зардал:	сая.төг	152,501.7	151,997.0	147,259.6	(4,737.3)	-3.1	
	Худалдаж авах ДЭХ-ний өртөг	сая.төг	115,227.0	102,068.9	97,668.7	(4,400.2)	-4.3	
	Түгээх,хангах үйл ажиллагааны зардал	сая.төг	36,738.5	48,401.4	48,025.9	(375.5)	-0.8	
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	536.2	1,526.7	1,565.1	38.4	2.5	
5	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.03	1.00	0.99	(0.02)	-1.6	
6	Татварын өмнөх ашиг,алдагдал	сая.төг	(3,834.9)	1,315.7	4,266.1	2,950.4	224.2	
7	Нийт авлага:	сая.төг	28,989.7	32,502.2	27,248.7	(5,253.5)	-16.2	
	ДЭХ-ний авлага	сая.төг	2,081.0	1,930.0	1,962.8	32.8	1.7	
	Бусад авлага	сая.төг	1,807.4	1,801.7	1,755.7	(46.0)	-2.6	
	Тайлант онд хэрэглэгчдээс авах авлага	сая.төг	3,888.4	3,731.7	3,718.4	(13.3)	-0.4	
	Нэхэмжлээгүй авлага	сая.төг	25,101.3	28,770.5	23,530.2	(5,240.2)	-18.2	
	Борлуулалтын авлага цуглуулалтын хувь	%	101.6	97.9	101.0	0,0	3.2	
8	Нийт өр төлбөр	сая.төг	113,692.8	157,694.1	138,525.6	(19,168.5)	-12.2	
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	103,744.6	148,014.2	134,261.9	(13,752.3)	-9.3	
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	9,948.2	9,679.9	4,263.7	(5,416.2)	-56,0	
9	Хөрөнгө оруулалт,их засвар	сая.төг	7,772.1	8,130.1	8,089.8	(40.3)	-0.5	
10	Цалингийн сан	сая.төг	14,169.2	18,898.9	18,898.3	(0,5)	0,0	
	Ажиллагсдын тоо	тоо	388	395	389	(6)	-1.5	
	Дундаж цалин /сараар/	мян.төг	3,043.2	3,987.1	4,048.5	61.4	1.5	

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 1,078.2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмнөх аудитаар Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор олгосон 28 айлын орон сууц бүртгэлтэй байсныг авлагаар бүртгэх, зохих шийдвэр гаргуулах асуудлыг шийдвэрлээгүй байсан.Тус орон сууцууд иргэдийн өмчлөх эрхээр үл хөдлөх хөрөнгөд бүртгэсэн тул байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгүүд бодитоор оршин байхгүй, авлагаар бүртгээгүй байна.	1	1,078.2			1	1,078.2	1	1,078.2				
Дүн	1	1,078.2			1	1,078.2	1	1,078.2				

3.2. Аудитаар нийт 107.0 сая төгрөгийн зөрчлийг¹ илрүүлж, 22.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 84.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэгдэл цалин урамшуулалд нийт 22.6 сая төгрөг олгосон нь орон тоо батлаагүй, байгууллагын чиг үүрэг гүйцэтгээгүй ажилтанд үр ашиггүй зардал гаргасан байна.	1	22.6	1	22.6				
Цалин хөлсний бүрэлдэхүүнийг 5 төрөл, 15 үзүүлэлтээр тооцон цалинг олгохоор журамд заасан боловч цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээр 35 үзүүлэлтээр бүртгэж, тайлагнасан нь үр ашигтай, хэмнэлттэй байх, энгийн ойлгомжтой байх зарчимд нийцэхгүй байна.	1	-					1	-
Тухайн байгууллага ахмадын сан байгуулаагүй, тэмдэглэлт баяр ёслол, 50,60 насны ой, 20 жил, 25 жилээс дээш ажилласны мөнгөн урамшуулалд нийт 84.4 сая төгрөг зарцуулсан байна.	1	84.4					1	84.4
Дүн	3	107.0	1	22.6			2	84.4

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.